

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Үндсэн хөрөнгийн талаар	12
3.2	Шилэн дансны талаар.....	12
3.3	Худалдан авах ажиллагааны талаар	12
3.4	Зардлын дансны талаар	13
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6	Аудит хийгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ ТЭМҮҮЛЭЛ
ЛАБОРАТОРИ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ТӨМӨРЧӨДӨР ТАНАА

2019.02.25 № 06/228
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн захирал Д.Төмөрчөдөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 30-наас 2019 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Аккурэйт финанс Аудит ХХК-ийн баг хариуцаж хэрэгжүүлэв. Монгол тэмүүлэл лаборатори сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Аккурэйт финанс Аудит ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Монгол тэмүүлэл лаборатори сургууль нь чиг. үүрэгтэйгээ нийцсэн зорилго зорилт дэвшүүлж, хэрэгжүүлж байна. Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн зорилго нь үндэсний хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэх, хэрэгжүүлэх, харьцуулан судлах, турших, хөгжүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

БСШУЯ-ны сайдын 2011 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 298 тоот тушаалаар БСШУЯ-ны харъяа Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага, суурь, бүрэн дунд боловсролын судалгаа, шинжилгээ туршилт, ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөрөөр хос хэлний сургалт

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан

бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нийгмийн Даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай
- Төрийн сангийн үйл ажиллагааны журам
- Төсвийн санхүүжилт болон зарцуулалт
- Төсвийн байгууллагын мөнгөн кассын журам

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Үүнд: 2018 оны 6 дугаар сарын 07-ны өдөр Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд төсвийн зарлагын талаар заалт нэмж, өөрчлөн найруулсан.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол тэмүүлэл лаборатори сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous 3.0” програм хангамж ашигладаг байна.

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийн нэг хувиар сонгов.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон нь улсын төсвөөс санхүүжилтийн орлого ордогтой холбоотой юм.

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны нийт зардал 1,042,363.2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 10,423.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	10,217.0	
	Дүн	4	10,217.0	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулав.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад багш ажилтан албан хаагчдын томилолтын зардлын тооцоог гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулж амжаагүй болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой боловсролын судалгаа, ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 776,866.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, нэмэлт санхүүжилтээр 91,364.7 мянган төгрөг орсон байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Монгол тэмүүлэл лаборатори сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансанд:

- 2018 оны 1-12 сарын батлагдсан төсөв,
- 2018 оны 1-12 төсвийн гүйцэтгэлийн мэдээ,
- 2018 онд төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, хэтрэлт хэмнэлтийн мэдээ,
- 2018 оны цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээний мэдээг тус тус байршуулсан байна.

2018 онд шилэн дансны цахим санд мэдээллүүдийг Тухай бүрт нь оруулах мэдээлэл 1, Сар бүр оруулах мэдээлэл 3, Улирал бүр оруулах мэдээлэл 1, Бүтэн жилээр оруулах мэдээлэл 4-ийг хугацаа хожимдуулсан буюу засвар оруулан байршуулсан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага, татварын байгууллагад өгөх ХХОАТ-ын өглөг барагдуулах, Үндсэн хөрөнгө бараа материалын дансанд бүртгэгдэх хөрөнгө, бараа материалыг зөв ангилах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэвшүүлэх зэрэг зөвлөмж өгөгдсөн. Шилэн дансны хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэж бараа материалын дансанд бүртгэсэн зарим зүйлсийг залруулан бүртгээгүй. Зөвлөмжийн биелэлт 90 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Үндсэн хөрөнгийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хөрөнгийг ангилал хооронд буруу бүртгэж, бараа материалын дансанд бүртгэх зарим зүйлсийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн нь НББОУС-ын үндсэн хөрөнгө, бараа материалын тодорхойлолтод нийцэхгүй байна,

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материал, хөрөнгийн элэгдэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө бараа материалын дансанд бүртгэгдэх хөрөнгө, бараа материалыг зөв ангилах, залруулан бүртгэх, зөрчлийг дахин давтахгүй байх,

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж залруулсан.

3.2 Шилэн дансны талаар

3.2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэвшүүлээгүй, сар бүр оруулах мэдээлэл, Тухай бүр оруулах мэдээллийн-Бусад мэдээлэл, Тухайн жилд төсөвт өөрчлөлт орсон нэмэлт өөрчлөлт, Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт...гэх мэт 9 мэдээлийг хугацаанд нь оруулаагүй буюу засварласан байна.

3.2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг мөрдөж ажиллаагүй байх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахгүй, тайлан мэдээ цаг хугацаандаа үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх,

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн дагуу ажиллах, зөрчлийг дахин давтахгүй байх,

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид энэ зөрчлийг давтахгүй байхаар анхааран зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Худалдан авах ажиллагааны талаар

3.3.1 Илрүүлэлт:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.2 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн А/196 тоот тушаалыг үндэслэн Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн захирлын 2018 оны 02 дугаар

сарын 28-ны өдрийн А/04 тоот тушаалаар олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001-ийг нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх Альфа Сист консалтинг ХХК-тай 10.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. Гэрээний төлбөрийг шилэн дансны мэдээлэлд өссөн дүнгээр тусгаагүй

3.3.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг мөрдөж ажиллаагүй байх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахгүй тайлан мэдээ цаг хугацаандаа үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх,

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалтыг мөрдөж ажиллах, зөрчлийг дахин давтахгүй байх,

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Зардлын дансны талаар

3.4.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд ангилал буруу бүртгэж, бараа материалын дансанд бүртгэх зарим зүйлсийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж элэгдэл тооцон 217,0 мянган төгрөгийг зардалд тусгасан.

3.4.2 Эрсдэл:

НББОУС-ын үндсэн хөрөнгө, бараа материалын тодорхойлолтонд нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламж мэдэгдлүүд зөрчигдөх,

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө бараа материалын дансанд бүртгэгдэх хөрөнгө, бараа материалыг зөв ангилан залруулан бүртгэх, зөрчлийг дахин давтахгүй байх,

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж залруулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	111 679 870,83	136 745 715,66
2	Кассанд байгаа бэлэн мөнгө		110,00
3	АВЛАГА	950 699,17	-
4	Бусад авлага	950 699,17	-
5	Байгууллагаас авах авлага	950 699,17	-
6	БАРАА МАТЕРИАЛ	110 729 171,66	136 745 605,66
7	Бичиг хэрэг	1 285 930,00	1 733 302,00
8	Аж ахуйн материал	108 695 772,66	126 170 835,66
9	Хүнсний материал	16 945,00	18 778,00
10	Бусад хангамжийн материал	730 524,00	8 822 690,00
11	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4 299 090 599,34	4 181 994 429,09
12	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4 299 090 599,34	4 181 994 429,09
13	Биет хөрөнгө	4 298 897 786,80	4 177 263 104,89
14	Барилга байгууламж	3 456 901 301,72	3 456 901 301,72
15	Хуримтлагдсан элэгдэл	10 089 865,82	-70 629 060,74
16	Авто тээврийн хэрэгсэл	98 458 333,00	98 458 333,00
17	Хуримтлагдсан элэгдэл	-60 168 981,40	-76 578 703,60
18	Машин, тоног төхөөрөмж	101 573 040,00	176 501 709,44
19	Хуримтлагдсан элэгдэл	-26 832 182,08	-62 029 153,34
20	Тавилга, аж ахуйн эд хогшил	163 599 054,30	164 372 969,90
21	Хуримтлагдсан элэгдэл	-78 013 419,92	-95 790 650,81
22	Бусад үндсэн хөрөнгө	653 998 698,28	653 998 698,28
23	Хуримтлагдсан элэгдэл	-11 235 691,28	-78 649 838,96
24	Номын фонд	10 707 500,00	10 707 500,00
25	Биет бус хөрөнгө	192 812,54	4 731 324,20
26	Програм хангамж	1 185 000,00	6 627 546,00
27	Хасагдуулга	-992 187,46	-1 896 221,80
28	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4 410 770 470,17	4 318 740 144,75
29	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	91 031,66	-
30	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	91 031,66	-
31	Өглөг	91 031,66	-
32	Ажиллагчидтай холбогдсон өглөг	91 031,66	-
33	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	4 410 679 438,51	4 318 740 144,75
34	Засгийн газрын хувь оролцоо	4 410 679 438,51	4 318 740 144,75
35	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн	265 942 620,50	265 942 620,50
36	Өмч: -Төрийн өмч	265 942 620,50	265 942 620,50
37	Хуримтлагдсан үр дүн	4 144 736 818,01	4 052 797 524,25
38	Өмнөх үеийн үр дүн	-43 152 414,67	4 144 736 818,01
39	Тайлант үеийн үр дүн	4 187 889 232,68	-91 939 293,76
40	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	4 410 770 470,17	4 318 740 144,75

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4 894 773 093,53	952 172 707,04
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4 193 916 993,53	83 941 227,04
3	Нийтлэг татварын бус орлого	4 193 916 993,53	83 941 227,04
4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4 193 916 993,53	83 941 227,04
6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	840 000,00
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4 193 916 993,53	83 101 227,04
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	700 856 100,00	868 231 480,00
9	Нэмэлт санхүүжилтийн орлого	12 736 000,00	91 364 680,00
10	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	-	80 304 680,00
11	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12 736 000,00	11 060 000,00
12	Төсвийн захирагчдаас	688 120 100,00	776 866 800,00
13	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	688 120 100,00	776 866 800,00
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	702 992 692,85	1 042 363 249,12
15	УРСГАЛ ЗАРДАЛ	690 092 689,85	1 041 523 219,01
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690 092 689,85	1 041 523 219,01
17	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	502 872 331,66	591 464 277,00
18	Цалин	279 349 224,66	591 464 277,00
19	Нэмэгдэл цалин	181 794 900,00	-
20	Унаа хоолны хөнгөлөлт	21 142 511,00	-
21	Урамшуулал	20 585 696,00	-
22	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56 544 987,83	70 016 290,17
23	Тэтгэврийн даатгалын шимтгэл	35 964 057,83	47 378 846,34
24	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5 508 660,00	6 009 012,00
25	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4 557 456,00	4 726 569,00
26	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	923 111,00	1 092 694,00
27	Эрүүл мэндийн даатгалын хураамж	9 591 703,00	10 809 168,83
28	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8 118 400,00	49 714 445,00
29	Гэрэл цахилгааны зардал	3 914 458,00	23 879 043,00
30	Түлш, халаалтын зардал	2 629 615,00	17 142 555,00
31	Цэвэр, бохир усны зардал	1 574 327,00	8 692 847,00
32	Хангамж, бараа материалын зардал	11 930 301,40	15 857 238,60
33	Бичиг хэргийн материал	495 257,00	1 037 700,00
34	Тээвэр, шатахууны зардал	4 930 925,00	4 711 030,00
35	Шуудан холбоо интернетийн төлбөр	3 296 752,00	5 895 226,00
36	Ном хэвлэлийн зардал	2 074 370,00	-
37	Хог хаягдал устгах, цэвэрлэх	180 000,00	1 548 000,00
38	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	952 997,40	2 665 282,60
39	Нормативт зардал	160 334,00	-
40	Нормын хувцас, зөөлөн эдлэл	160 334,00	-
41	Эд хогшил, урсгал засварын зардал	-	353 000,00
42	Багаж хэрэгсэл	-	353 000,00

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

43	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16 876 710,00	78 445 658,00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	16 032 010,00	76 284 358,00
45	Аудит ,баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	712 800,00	2 000 000,00
46	Тээврийн хэрэгслийн татвар	131 900,00	128 300,00
47	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	33 000,00
48	Бараа үйлчилгээний бусад зардал	93 749 958,96	235 672 310,24
	Бараа үйлчилгээний бусад зардал		2 669 700,00
49	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын загвар	27 187 413,00	33 042 004,63
50	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66 562 545,96	199 960 605,61
51	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12 900 003,00	840 030,11
52	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,00	840 030,11
53	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,00	840 030,11
54	Бусад урсгал шилжүүлэг	12 900 000,00	-
55	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж,урамшуулал	-	-
56	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	12 900 000,00	-
57	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
58	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
59	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (III=I-II)	4 191 780 400,68	-90 190 542,08
60	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	3 730 834,00	1 748 751,68
61	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3 730 834,00	672 920,68
62	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1 075 831,00
63	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-3 730 834,00	-1 748 751,68
64	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	4 188 049 566,68	-91 939 293,76

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	716 461 734,00	869 071 480,00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3 202 000,00	840 000,00
3	Нийтлэг татварын бус орлого	3 202 000,00	840 000,00
4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3 202 000,00	840 000,00
5	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	-
6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3 202 000,00	840 000,00
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	713 259 734,00	868 231 480,00
8	Нэмэлт санхүүжилтийн орлого	12 736 000,00	91 364 680,00
9	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	-	80 304 680,00
10	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12 736 000,00	11 060 000,00
11	Төсвийн захирагчдаас	688 120 100,00	776 866 800,00
12	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	688 120 100,00	776 866 800,00
13	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12 403 634,00	-
14	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	12 403 634,00	
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	673 430 734,00	854 739 210,00
16	УРСГАЛ ЗАРДАЛ	673 430 734,00	854 739 210,00
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	660 530 731,00	853 899 179,89
18	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	515 184 934,00	589 811 799,66
19	Цалин	291 661 827,00	291 684 968,00
20	Нэмэгдэл цалин	181 794 900,00	159 885 862,00
21	Унаа хоолны хөнгөлөлт	21 142 511,00	34 320 000,00
22	Үр дүнгийн урамшуулал	20 585 696,00	103 920 969,66
23	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58 390 000,00	70 777 500,00
24	Тэтгэврийн даатгалын шимтгэл	37 809 070,00	49 336 800,00
25	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4 703 879,00	4 931 840,00
26	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5 466 887,00	4 716 175,00
27	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	923 111,00	1 072 035,00
28	Эрүүл мэндийн даатгалын хураамж	9 487 053,00	10 720 650,00
29	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8 118 400,00	49 714 445,00
30	Гэрэл цахилгааны зардал	3 914 458,00	23 879 043,00
31	Түлш, халаалтын зардал	2 629 615,00	17 142 555,00
32	Цэвэр, бохир усны зардал	1 574 327,00	8 692 847,00
33	Хангамж, бараа материалын зардал	12 327 000,00	22 579 300,00
34	Бичиг хэргийн материал	749 860,00	1 945 643,00
35	Тээвэр, шатахууны зардал	5 132 165,00	4 711 030,00
36	Шуудан холбоо интернетийн төлбөр	3 296 752,00	5 895 226,00
37	Ном хэвлэлийн зардал	2 074 370,00	4 465 490,00
38	Хог хаягдал устгах, цэвэрлэх	180 000,00	1 548 000,00
39	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	893 853,00	4 013 911,00
40	Нормативт зардал	190 400,00	-
41	Нормын хувцас, зөөлөн эдлэл	190 400,00	-
42	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1 040 000,00
43	Багаж техник хэрэгсэл	-	1 040 000,00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35 534 597,00	78 766 093,00

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

45	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	34 689 897,00	76 604 793,00
46	Аудит ,баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	712 800,00	2 000 000,00
47	Тээврийн хэрэгслийн татвар	131 900,00	128 300,00
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	33 000,00
49	Бараа үйлчилгээний бусад зардал	30 975 800,00	41 210 042,23
50	Бараа үйлчилгээний бусад зардал	3 202 000,00	-
51	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын загвар	27 773 800,00	41 210 042,23
52	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12 900 003,00	840 030,11
53	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,00	840 030,11
54	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,00	840 030,11
55	Бусад урсгал шилжүүлэг	12 900 000,00	-
56	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
57	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	12 900 000,00	-
58	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
59	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
60	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	43 031 000,00	14 332 270,00
61	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
62	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	42 840 600,00	14 332 160,00
63	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42 840 600,00	14 332 160,00
64	Дотоод эх үүсвэрээр	42 840 600,00	14 332 160,00
65	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42 840 600,00	14 332 160,00
66	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-42 840 600,00	-14 332 160,00
67	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	110,00
68	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
69	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		110,00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	265 942 620,50	-43 152 414,67	222 790 205,83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	4 187 889 232,68	4 187 889 232,68
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	265 942 620,50	4 144 736 818,01	4 410 679 438,51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-91 939 293,76	-91 939 293,76
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	265 942 620,50	4 052 797 524,25	4 318 740 144,75

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	776 866 800,00	776 866 659,89	140,11	100,0%
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	776 866 800,00	776 866 659,89	140,11	100,0%
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	776 866 800,00	776 866 659,89	140,11	100,0%
Бараа, үйлчилгээний зардал	776 866 800,00	776 866 659,89	140,11	100,0%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561 884 300,00	561 884 299,66		100,0%
Үндсэн цалин	278 068 400,00	273 964 968,00	4 103 432,00	98,5%
Нэмэгдэл цалин	144 938 000,00	153 085 862,00	-8 147 862,00	105,6%
Унаа, болон бусад нөхөн олговор	34 320 000,00	34 320 000,00	-	100,0%
Урамшуулал	104 557 900,00	100 513 469,66	4 044 430,34	96,1%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67 811 400,00	67 811 400,00		100,0%
Тэтгэврийн даатгал	47 359 400,00	47 359 400,00	-	100,0%
Тэтгэмжийн даатгал	4 734 100,00	4 734 100,00	-	100,0%
ҮОМШӨ-ний даатгал	4 469 000,00	4 469 000,00	-	100,0%
Ажилгүйдлийн даатгал	1 022 600,00	1 022 600,00	-	100,0%
Эрүүл мэндийн даатгал	10 226 300,00	10 226 300,00	-	100,0%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48 714 500,00	48 714 445,00		100,0%
Гэрэл цахилгаан	16 414 500,00	22 879 043,00	-6 464 543,00	139,4%
Түлш, халаалт	25 500 000,00	17 142 555,00	8 357 445,00	67,2%
Цэвэр, бохир ус	6 800 000,00	8 692 847,00	-1 892 847,00	127,8%
Хангамж, бараа материалын зардал	21 785 800,00	21 785 800,00		100,0%
Бичиг хэрэг	3 600 000,00	1 507 143,00	2 092 857,00	41,9%
Тээвэр (шатахуун)	5 213 900,00	4 611 030,00	602 870,00	88,4%
Шуудан холбоо, интернетийн төлбөр	7 900 000,00	5 640 226,00	2 259 774,00	71,4%
Ном хэвлэл	3 571 900,00	4 465 490,00	-893 590,00	125,0%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500 000,00	1 548 000,00	-1 048 000,00	309,6%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1 000 000,00	4 013 911,00	-3 013 911,00	401,4%
Эд хогшил худалдан авах	2 000 000,00	2 000 000,00		100,0%
Багаж, техник хэрэгсэл	2 000 000,00	2 000 000,00		100,0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	39 961 300,00	39 961 300,00	-	100,0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37 800 000,00	37 800 000,00	-	100,0%
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2 000 000,00	2 000 000,00		100,0%
Тээврийн хэрэгслийн татвар	128 300,00	128 300,00		100,0%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	33 000,00	33 000,00		100,0%
Бараа үйлчилгээний бусад зардал	34 709 500,00	34 709 415,23	84,77	100,0%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34 709 500,00	34 709 415,23	84,77	100,0%

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	776 866 800,00	776 866 769,89	840 030,11	100,0%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	776 866 800,00	776 026 769,89	840 030,11	99,9%
Улсын төсвөөс санхүүжих	776 866 800,00	776 026 769,89	840 030,11	99,9%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	840 000,00	-840 000,00	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	840 000,00	-840 000,00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		110,00	-110,00	
АЖИЛЛАГСДЫН ТОО	41	41		100,0%
Удирдах ажилтан	1	1		100,0%
Гүйцэтгэх ажилтан	31	31		100,0%
Үйлчлэх ажилтан	9	9		100,0%
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41	41		100,0%
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	27	27		100,0%
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	14	14		100,0%

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
1. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91 364 680,00	91 364 680,00	0.00	100.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	91 364 680,00	91 364 680,00	0.00	100.00
Бараа, үйлчилгээний зардал	91 364 680,00	91 364 680,00	0.00	100.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27 927 500,00	27 927 500,00	0.00	100.00
Үндсэн цалин	17 720 000,00	17 720 000,00	0.00	100.00
Нэмэгдэл	6 800 000,00	6 800 000,00	0.00	100.00
Урамшуулал	3 407 500,00	3 407 500,00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2 966 100,00	2 966 100,00	0.00	100.00
Тэтгэврийн даатгал	1 977 400,00	1 977 400,00	0.00	100.00
Тэтгэмжийн даатгал	197 740,00	197 740,00	0.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	247 175,00	247 175,00	0.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	49 435,00	49 435,00	0.00	100.00
Эрүүл мэндийн даатгал	494 350,00	494 350,00	0.00	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1 000 000,00	1 000 000,00	0.00	100.00
Гэрэл цахилгаан	1 000 000,00	1 000 000,00	0.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	793 500,00	793 500,00	0.00	100.00
Бичиг хэрэг	438 500,00	438 500,00	0.00	100.00
Тээвэр (шатахуун)	100 000,00	100 000,00	0.00	100.00
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	255 000,00	255 000,00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	52 176 953,00	52 176 953,00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52 176 953,00	52 176 953,00	0.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	6 500 627,00	6 500 627,00	0.00	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6 500 627,00	6 500 627,00	0.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	91 364 680,00	91 364 680,00	0.00	100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	91 364 680,00	91 364 680,00	0.00	100.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны	80 304 680,00	80 304 680,00	0.00	100.00
Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	11 060 000,00	11 060 000,00	0.00	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	0.00	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	0.00	100.00
АЖИЛЛАГСДЫН ТОО	41,00	41,00	0.00	100.00
Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
Гүйцэтгэх ажилтан	31	31	0.00	100.00
Үйлчлэх ажилтан	9	9	0.00	100.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41	41	0.00	100.00
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	27	27	0.00	100.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	14	14	0.00	100.00

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.25	Аудитын нэр:	Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2019/31/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол тэмүүлэл лаборатори сургууль			Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэвшүүлээгүй, сар бүр оруулах мэдээлэл, Тухай бүр оруулах мэдээллийн-Бусад мэдээлэл, Тухайн жилд төсөвт өөрчлөлт орсон нэмэлт өөрчлөлт, Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт...гэх мэт мэдээнүүдийг хугацаанд нь оруулаагүй 9 мэдээ хоцроосон байна. Энэ нь “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэвшүүлэхэд, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнууд болон дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах, төсвийг зүй зохистой зарцуулах, татвар төлөгчдийн итгэлийг бүрдүүлэх, төсвийн сахилга бат, хариуцлага, дотоод хяналтыг дээшлүүлэх нь чухал” гэсэнтэй нийцэхгүй байна.	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	Х.Орхончимэг
2	Урд оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй Үндсэн хөрөнгийн дансанд ангилал буруу бүртгэж, бараа материалын дансанд бүртгэх зарим зүйлсийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн нь НББОУС-ын үндсэн хөрөнгө, бараа материалын тодорхойлолт болон үндсэн хөрөнгийн элэгдлийг СТОУС-ын дагуу тооцоолох,	-	зөвлөмж	Нягтлан бодогч	Х.Орхончимэг
3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46-р зүйл, Төсвийн тухай хуулийн 3-р бүлгийн 16.5.2 дахь заалт, Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2017-09-20 ны өдрийн А/196-р тушаалыг үндэлэн 2018 оны 02 сарын 28 ны өдрийн А/04 тоот захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулан Монгол тэмүүлэл лаборатори	10,000.0	зөвлөмж	Нягтлан бодогч	Х.Орхончимэг

	сургуульд олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001-ийг нэвтрүүлэх ажлын хэсэг байгуулсан. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээг үзүүлэх аж ахуйн нэгж хуулийн этгээдийг Эйч Эс И Кью консалтинг ХХК 12,0 сая, Альфа Сист консалтинг ХХК 10,0 сая төгрөгийн санал өгч Альфа Сист консалтинг ХХК шалгарсан байна.				
4	Үндсэн хөрөнгийн дансанд ангилал буруу бүртгэж, бараа материалын дансанд бүртгэх зарим зүйлсийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн, аж ахуйн материал дээр элэгдэл тооцож зардлаар тусгасан. /залруулах/	217.0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Х.Орхончимэг
	Дүн				

